

## АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

### I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Төрийн албаны тухай хууль, Дотоодын цэргийн тухай хууль

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг  
баталсан огноо:

Байгууллагын нэр:

Цагдаагийн ерөнхий газар

Нэгжийн нэр:

Удирдлага

Албан тушаалын нэр:

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Дэд дарга

ТТ-1

Ажлын цаг:

Ажлын өдөр 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр  
хороо Самбуугийн гудамж 18

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

### II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын алба хаагч, ажилтан гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх ажлыг зохион байгуулах, тэдгээрт холбогдох гомдол, мэдээллийг шалгаж шийдвэрлэх, аюулгүй байдлыг хангах, Төрийн болон албаны нууцын тухай, Байгууллагын нууцын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагааг сурталчилах, алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангах, үр дүнг тооцоход оршино.

**Албан тушаалын зорилт:**

1. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг зохицуулсан хууль, тогтоомжийн хэрэгжилтийг мэргэжил, арга зүйгээр хангах, зөвлөх, удирдлагын шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах, хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулж, үр дүнг тооцон, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулахад хяналт тавих;
2. Алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийж, байгууллагын эрсдэлийг тодорхойлж, үнэлэх ажлыг удирдан зохион байгуулах;
3. Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллага, алба хаагч, ажилтан гэмт хэрэг, зөрчил үйлдэх, ёс зүй, сахилтын зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх, судалгаа хийх, шалтгаан, нөхцөлийг арилгах арга хэмжээ авах;
4. Цагдаа, дотоодын цэргийн алба хаагч, ажилтны мэргэжлийн бэлтгэл, давтан болон албаны сургалтын бодлогыг хэрэгжүүлж, ажиллах;
5. Иргэд, олон нийт, алба хаагчдад цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагааг сурталчлах ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах – Т, Хариуцан гүйцэтгэх – Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	<p>1. Цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлэхээр тусгагдсан ажил, арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжилтийг хангах, биелэлт үр дүнг тооцож, тайлгахаас, мэргэжлийн удирдлага, зохион байгуулалтаар хангах, хууль сахиулах чиглэлээр баримтлах бодлого, үндсэн чиглэл, ойрын болон хэтийн зорилт тодорхойлох, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж, хүний нөөцийн бодлого боловсруулж, гадаад харилцаа, хамтын ажиллагааны чиглэлийг боловсруулж, өргөжүүлэн хөгжүүлэх ажлыг зохион байгуулах үйл ажиллагаанд хяналт тавиж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах;</p> <p>2. Архивын хууль тогтоомжийн дагуу хадгалах, хамгаалах, лавлагаа олгох, архив, албан хэрэг хөтлөлттэй холбоотой хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд нь хяналт тавих;</p> <p>3. Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын алба хаагчийн бие, бялдар, бэлтгэлжилтийн стандарт тогтоох, алба хаагчдын түвшинг</p>	Хууль тогтоомжийн хэрэгжилт, байгууллага, алба хаагчийн аюулгүй байдал хангагдсан байна.	X, Г, Ш

	<p>тодорхойлох, бие, бялдар бэлтгэлжилтийг зохих түвшинд нь хургэх биений тамир, спортын арга хэмжээг зохион байгуулах үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах;</p> <p>4.Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллага, алба хаагчийн аюулгүй байдал, байгууллагын нууцыг хангах чиглэлээр батлагдсан хууль тогтоомж, тушаал шийдвэрийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж, хяналт тавих;</p> <p>5.Авлигын эсрэг хууль, Нийтийн албанц нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Цагдаагийн еренхий газрын Авилаас урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн хийх ажлын төлөвлөгөөний биелэлт, үр дүнг тооцох;</p> <p>6.Удирдлагаас баталсан хуваарийн дагуу алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг шалгаж, дүнг танилцуулах;</p> <p>7.Техник, криптографийн арга хэрэгсэл ашиглан шифр харилцааны үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, албаны мэдээллийн аюулгүй байдлыг хангах.</p>		
2 дугаар зорилтын хүрээнд	<p>1.Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн хүрээнд байгууллагын өмчийн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтын байдал, бүртгэл санхүүгийн үйл ажиллагаанд баримтын шалгалтыг зохион байгуулж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах, түүнд хяналт тавих;</p> <p>2.Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын хэмжээнд эрсдэлийн удирдлага, үнэлгээний тогтолцоог нэгтгэн зохион байгуулж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;</p> <p>3.Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудит хийж дүгнэлт, санал, зөвлөмж өгөх үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;</p>	<p>Байгууллагын үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгч, эрсдэл тооцогдсон байна.</p>	X, Г Ш

	4.Байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг нэгтгэн, бодлогын хувилбар, санал, дүгнэлт, зөвлөмж гарган удирдлагад танилцуулж, нэгжүүдэд хүргүүлж, биелэлтэд хяналт тавих.		
3 дугаар зорилтын хүрээнд	<p>1.Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны "Өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх журам"-ын дагуу иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд хяналт тавих;</p> <p>2.Хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэгдсэн нийтлэлийн мөрөөр албаны шалгалт явуулах ажиллагаанд хяналт тавих;</p> <p>3.Цагдаа, дотоодын цэргийн байгууллага, алба хаагчдын талаар иргэдээс ирүүлсэн гомдол, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, хэрэгжүүлэх ажил, арга хэмжээ, анхаарах асуудал, зөвлөмжийг боловсруулж, хэрэгжилтийг хангуулах;</p> <p>4.Алба хаагчийн хууль ёсны эрх ашиг, сонирхол зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсэн тохиолдолд хамгаалуулах;</p> <p>5.Цагдаагийн алба хаагчаас хууль тогтоомж, ёс зүйг зөрчсөн талаар иргэд, байгууллагаас гаргасан гомдол, мэдээлэл, хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэгдсэн нийтлэлийн мөрөөр албаны шалгалт явуулж, дүнг удирдлагад танилцуулж шийдвэр гаргуулан хэрэгжилтийг хангуулах, хууль ёсны эрх ашиг сонирхлыг хамгаалах ажлыг зохион байгуулах.</p>	Алба хаагчдын сахилга, ёс зүй дээшилж, эрх ашиг, сонирхол хангагдсан байна.	X, ГШ
4 дүгээр зорилтын хүрээнд	<p>1.Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын сургалт, хүний хөгжлийн бодлого чиг үүргийг хэрэгжүүлэх, алба хаагчдын эрэлт, хэрэгцээнд нийцсэн сургалтыг зохион байгуулах ажлыг удирдлага зохион байгуулалтаар хангах;</p> <p>2.Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвөөс зохион байгуулж буй сургалтын ажлын явц, үр дунд жил бүр</p>	Алба хаагчдын мэдлэг, ур чадвар дээшилсэн байна.	X, ГШ

	<p>хяналт, шинжилгээ хийж, чанар, үр дүнг сайжруулах;</p> <p>3.Гадаад дотоодын их дээд сургууль, коллеж, мэргэжлийн байгууллага, төрийн ба төрийн бус байгууллага олон улсын байгууллагатай сургалтын чиглэлээр хамтран ажиллах;</p> <p>4.Сургалт явуулах орчинг бүрдүүлэх, шинэлэг техник, технологи, арга хэлбэрийг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллах.</p>		
5 дугаар зорилтын хүрээнд	<p>1.Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, бодлого чиглэлийг олон нийтэд сурталчлах ажилд хяналт тавих;</p> <p>2.Олон нийтэд түшиглэсэн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, байгууллага, алба хаагчдын дунд урлаг, соёлын ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;</p> <p>3.Урлаг, соёлын үйл ажиллагаагаар дамжуулан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжийг сурталчлах ажлыг зохион байгуулах, үр дүнг тооцох;</p> <p>4.Цагдаагийн ерөнхий газрын даргаас тусгайлан хариуцуулсан үүрэг, чиглэлийг хэрэгжүүлэх;</p> <p>5.Цагдаагийн ерөнхий газрын даргын шийдвэрээр ахлан ажиллах орон тооны бус зөвлөл, комисс, ажлын хэсгийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, дүнг танилцуулах;</p> <p>6.Хууль тогтоомж, дүрэм, журмаар хүлээлгэсэн ажлын байрны зорилгод нийцсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх;</p> <p>7.Авлига, хүнд суртлаас ангид байж хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн, шударга ёсыг эрхэмлэн "Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм"-ийг чанд сахих;</p> <p>8.Нийтийн албанц нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллах.</p>	Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа иргэдэд нээлттэй болсон байна.	X, Г Ш

### III АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол

- магистр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй.

Мэргэжил		- эрх зүй (042101).
Мэргэшил		- төрийн удирдлагын чиглэлээр мэргэшсэн байх.
Туршлага		- цагдаагийн албан 15-аас доошгүй жил ажилласан, нийтийн хэв журам хамгаалах, гүйцэтгэх болон мөрдөн байцаах ажлын дадлага туршлагатай, улс төрийн албан тушаал эрхэлж байгаагүй байх.
Ур чадвар	Удирдан зохион байгуулах	<ul style="list-style-type: none"> <li>- эрсдэлийг урьдчилан тооцоолох, гарах арга замыг тодорхойлох, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх;</li> <li>- байгууллагын үйл ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэлийг дүгнэх;</li> <li>- алба хаагчдын ажил үүргийг тэнцвэртэй хуваарилах;</li> <li>- алба хаагчдын санал, бодлыг сонсох, бүтээлч санаачилга, зөв хандлагыг дэмжих, мэдлэг, туршлага, ур чадварыг ашиглах;</li> <li>- саналын зөрүү, үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах;</li> <li>- алба хаагчийн ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, гүйцэтгэлийн зөрүүг арилгахад туслах зөвлөх, чиглүүлэх, шаардлага тавих;</li> <li>- бусад.</li> </ul>
	Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> <li>- мэдээлэлд тулгуурлан бүтэц, чиг үүргийн шинжилгээ хийх;</li> <li>- судалгааны үр дүн, шийдлийн хувилбаруудын шууд ба шууд бус үр дагаврыг харьцуулан үнэлэх;</li> <li>- хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд санал, зөвлөмж өгөх;</li> <li>- бусад.</li> </ul>
	Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> <li>- хуульд нийцсэн, оновчтой, үр дүнтэй шийдвэрийг шуурхай гаргах;</li> <li>- хууль тогтоомжийн тесөлд санал өгөх;</li> <li>- тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулж, зерэг, серег үр дагаврын талаар удирдлагад танилцуулах;</li> <li>- албан тушаалын бүрэн эрхийн хурээнд асуудлыг хууль болон ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх;</li> <li>- гаргасан шийдвэрийнхээ үр дагаврыг хариуцах;</li> <li>- бусад.</li> </ul>
Ур чадвар	Манлайлах	<ul style="list-style-type: none"> <li>- ёс зүйн хэм хэмжээг сахиж, зарчимч, тууштай, ажил хэрэгч байдлаар үлгэрлэх;</li> <li>- байгууллагын үйл ажиллагаанд шинэлэг санаа, ажил үйлчилгээг нэвтрүүлэх, алба хаагчдын шинэ санаачилга, бүтээлч үйл хандлагыг дэмжих;</li> <li>- хувийн зохион байгуулалт, ажлын цаг ашиглалтын хувьд хамт олныг үлгэрлэх;</li> <li>- байгууллагын үйл ажиллагааны шинэгэлийн үзэл санааг хамт олонд тайлбарлан таниулах, хэрэгжүүлэх;</li> <li>- байгууллагын стратеги зарилтыг тодорхойлоходоо хамт олны саналыг сонсох, тусгах, өөрчлөлтийг хийхдээ урьдчилан тооцоолж, манлайлан удирдах;</li> <li>- бусад.</li> </ul>
	Бусад	- англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албаны чиг үүргээ хэрэгжүүлэх чадвартай;

	<ul style="list-style-type: none"> <li>- албан тушаалын чиг үүргээ аливаа нөхцөлд хэрэгжүүлэх чадвартай байх;</li> <li>- багаар ажиллах, багийн амжилтыг үнэлэх, дэмжих, бусдад таниулах;</li> <li>- хамт олонч сэтгэлгээтэй, эерэг уур амьсгалыг бүрдүүлэн ажилладаг байх;</li> <li>- өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг, хамт олонгой хуваалцах хамтран ажиллах;</li> <li>- харилцааны орчин үеийн арга хэлбэрийг ашиглах;</li> <li>- төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн мэдлэгтэй, монгол хэл, найруулга зүйн чадвартай байх;</li> <li>- мэргэжлээрээ ажилласан туршлагатай байх;</li> <li>- компютерын хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт технологи ашиглах;</li> <li>- мэдээлэл, харилцаа холбооны технологийг төрийн удирдлагын үр нөлөө, төрийн үйлчилгээний чанарыг дээшлүүлэхэд ашиглах чадвартай байх;</li> <li>- авлига, хүнд суртлаас ангид байж хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн, шударга ёсыг эрхэмлэн "Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм"-ийг чанд сахих;</li> <li>- Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллах.</li> </ul>
--	---

#### IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЬЕКТ

Албан тушаалыг шууд харьялан удирдах албан тушаалын нэр:

- Хууль зүй, дотоод хэргийн сайд, Дэд сайд, Төрийн нарийн бичгийн дарга, Цагдаагийн ерөнхий газрын дарга, Тэргүүн дэд дарга.

<u>Албан тушаалд шууд харьялан удирдуулах албан тушаалын нэр, тоо:</u> <ul style="list-style-type: none"> <li>- Дотоод хяналт-аюулгүй байдлын газар</li> <li>- Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн газар, хэлтсийн дарга нар</li> <li>- Бусад цагдаагийн газар, хэлтсийн дарга нар</li> </ul>	<u>Бусад харилцах субъект</u> <ul style="list-style-type: none"> <li>- Тэргүүн дэд, дэд бөгөөд Нийслэлийн цагдаагийн удирдах газрын дарга;</li> <li>- Дотоодын цэргийн штабын дарга;</li> <li>- Алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын дарга, алба хаагчид;</li> <li>- Төрийн болон төрийн бус байгууллага;</li> <li>- Иргэн, хуулийн этгээд, мэргэжлийн байгууллага.</li> </ul>
--	---

#### V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

<u>Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:</u>  <b>Албан тушаалт-аюулгүй байдлын газар, хэлтсийн дарга нар</b> <b>ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН АЛБАН ТҮҮРГИЙГ ГҮЙЦЭТГЭГЧ.....</b> <b>Орлон</b> <b>Л.НЯМГЭРЭЛ</b> <b>(Гарын үсэг)</b>	<u>Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:</u> <b>Байгууллагын нэр:</b> <b>(Эцэг/эх/-ийн нэр,</b>
---	---

өөрийн нэр)  
2024 оны 01 дугаар сарын 08-ны өдөр

**VI.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫГ БАТАЛСАН:**

Байгууллагын нэр:

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

Шийдвэрийн огноо: .....

Дугаар: .....

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД

(Сарын үсэг)

(Эцэг/эх-/ийн нэр, өөрийн нэр)

2024 оны 01 дугаар сарын 08-ны өдөр

Б.ЭНХБАЯР

---oo---